



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/101

Бат-Өлзий сум


Тендер хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 24 дугаар зүйлийн 24.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бат-Өлзий сумын бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 02 дугаар зөвлөмжийг үндэслэн Сумын төвийг танилцуулах, сурталчлах өндөрлөгтэй болох ажлын тендер (ӨВАБӨСЗДТГ/20240101001)-ийг хүчингүй болгосугай.

2.Дээрх хүчингүй болсон тендерийг сонгон шалгаруулалтын харьцуулалтын аргаар дахин зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Н.Орхонтуул)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН